

АГУУЛГА

ЗУРГАН МЭДЭЭЛЭЛ	2
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛ	2
ОРШИЛ	3
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Төслийн нэр:	4
1.2 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:.....	4
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:.....	4
1.4 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ:	4
1.5 Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл:	4
1.6 Төслийн талбайн байршил:	4
ХОЁР. НҮҮРС БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ	6
2.1 Нүүрс баяжуулах үйлдвэр	6
2.2 Үйлдвэрийн ажиллах горим	7
2.3 Үйлдвэрийн технологи	8
2.4 Баяжуулалтын тоног төхөөрөмжийн ажиллах зарчим	9
2.4.1. ZM Хуурай баяжуулах төхөөрөмж	9
2.4.2. IDS рентгенээр ялгах төхөөрөмж.....	10
2.5. Дэд бүтэц.....	13
2.5.1. Усан хангамж.....	13
ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	18
ДӨРӨВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
ТАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
ЗУРГАА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
ДОЛОО. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)	26
ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	28

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	28
ХАВСРАЛТ 1. АЖ АХУЙ НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭ.....	30
ХАВСРАЛТ 2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛБАР	31
ХАВСРАЛТ 3. БОАЖЯ-НЫ ЛАВЛАГАА	48
ХАВСРАЛТ 4. БОМТ-НИЙ БАРЬЦАА ХӨРӨНГИЙН БАРИМТ.....	56
ХАВСРАЛТ 5. ТУХАЙН ЖИЛД АШИГЛАХ ХИМИЙН БОДИСЫН НЭР, ХЭМЖЭЭ	57

ЗУРГАН МЭДЭЭЛЭЛ

Зураг 1 Хөшөөтийн нүүрсний ордын байршлын зураг	5
Зураг 2. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт солих.....	7
Зураг 3. Хуурай баяжуулах үйлдвэрийн технологийн схем.....	8
Зураг 4. Нүүрс хуурай аргаар баяжуулах ZM төхөөрөмж	9
Зураг 5. Нүүрс хуурай аргаар баяжуулах ZM төхөөрөмжийн бүдүүвч схем.....	10
Зураг 6. IDS рентгенээр ангилах төхөөрөмж	11
Зураг 7. IDS рентгенээр ангилах төхөөрөмжийн ялгалт хийх зарчим	12
Зураг 8. Усан хангамжийн худгуудын байршил	13
Зураг 9. Мананжуулагч буу.....	15
Зураг 10. Тоос дарах шүрших систем	15
Зураг 11. Салхины наалт	16

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол.....	6
Хүснэгт 2. Хуурай баяжуулах хэсгийн хүчин чадал, ажиллах горим	8
Хүснэгт 3. Гүний худгийн үзүүлэлт	13
Хүснэгт 4. Ажилчдын унд ахуйн хэрэглээний усны зарцуулалт.....	14
Хүснэгт 5. Жилд шаардагдах тенхологийн усны хэрэглээ.....	17
Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсвийн задаргаа	20

ОРШИЛ

Хөшөөтийн чулуун нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр нь Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн нутагт Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт, Улаанбаатар хотоос баруун тийш 1300 км, Ховд хотоос зүүн урагш 210 км, Дарви сумаас баруун урагш 50 км, Цэцэг сумаас хойш 29 км-ийн зайд оршино.

Хөшөөтийн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл нь нийт 1885.6 га талбайг хамарсан MV-015289, MV-011888, MV-011887, MV-006525, MV-004322, MV-001640, MV-001414, MV-020299 тоот ашиглалтын 8 тусгай зөвшөөрөлтэйгээр нүүрс олборлох үйл ажиллагаа явуулж байна.

Хөшөөтийн чулуун нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа нь байгаль орчин, уул уурхай, зам тээвэр, барилга, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй зэрэг нийгмийн салбарын бүхий л төрлийг хамарсан цогц хэлбэрээр явагдаж байгаа бөгөөд түүнтэй холбогдох хууль, журам, заавар, стандартуудыг мөрдөн ажиллаж байна.

Цаашид уурхайн үйл ажиллагаа өргөжих тусам байгаль орчны ажлуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах ба мөн олон улсын дэвшилтэт технологийг байгаль орчныг хамгаалах ажилд нэвтрүүлэн ажиллах болно.

МоЭнКо ХХК нь 2007 оноос өрөмдлөг хайгуулын ажил эхэлсэн бөгөөд энэ үеэс эхлэн Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгаль хамгаалах чиглэлээр дараах ажлуудыг мэргэжлийн байгууллага болон компанийн дотоод нөөц бололцоогоор хийж гүйцэтгээд байна.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр:

Хөшөөтийн чулуун нүүрсний ордын нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр

1.2 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:

“МоЭнКо” ХХК

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4 дүгээр хороо, Сөүлийн гудамж 23, Түшиг төв,
3 давхар, Утас: (976)-7711-0567, (976)-9911-0170 Вэб хуудас: www.moenco.mn.

1.4 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ:

Улсын бүртгэлийн дугаар: 9019023025

Улсын регистрийн дугаар: 5141583



1.5 Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл:

Хөшөөтийн нүүрсний уурхай нь (MV-015289, MV-011888, MV-011887, MV-006525, MV-004322, MV-001640, MV-001414, MV-020299) тоот ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн 1885.6 га талбайг хамран үйл ажиллагаагаа явуулдаг. Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр нь 20 га талбайд үйл ажиллагаагаа явуулна.

1.6 Төслийн талбайн байршил:

Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр нь Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн нутагт Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт оршино. Тус орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 1300 км, Ховд хотоос зүүн урагш 210 км, Дарви сумаас баруун урагш 50 км, Цэцэг сумаас хойш 29 км, Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт далайн түвшнээс дээш 1900-2500 метр өндөрт оршдог.

Баяжуулах үйлдвэрийн байршил



Зураг 1 Хөшөөтийн нүүрсний ордын байршлын зураг

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол

№	X	Y	Талбайн
1	523933.78	5185387.26	1000 га
2	523937.39	5184421.98	
3	523940.44	5183650.34	
4	523092.66	5183646.98	
5	523098.55	5182103.61	
6	523098.54	5181884.08	
7	520683.17	5181876.26	
8	520658.52	5185407.23	

ХОЁР. НҮҮРС БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ


2.1 Нүүрс баяжуулах үйлдвэр

Нүүрс хуурай Баяжуулах үйлдвэр нь уурхайгаас 4 км, ажилчдын оффисоос 1.5 км зайд байрлана. Хөшөөтийн ордын нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр нь:

- Нүүрс хүлээн авах хэсэг
- Хуурай баяжуулах үйлдвэрийн хэсэг
- Овоолгын талбайн хэсэг
- Оффис, сэлбэг материалын агуулах

Хуурай баяжуулах үйлдвэрийн нийт талбай 20 га байхаар төлөвлөсөн. Үүнд:

1. Анхдагч нүүрс хүлээн авах хэсэг
2. Хүдэр бэлтгэх хэсэг /бутлалт, шигшилт/
3. Нүүрс хуурай баяжуулах үйлдвэр
4. Баяжмалын овоолго
5. Сэлбэг материалын агуулах
6. Галын усны нөөцийн сав болон насос станц
7. Хаягдал чулуулаг буулгах хэсэг
8. Оффис
9. Цахилгаан үүсгүүрийн өрөө
10. Авто машины зогсох талбай зэрэг орно.



Зураг 2. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт солих

2.2 Үйлдвэрийн ажиллах горим


Баяжуулах үйлдвэр нь жилд 330 хоног ажиллана, үйлдвэрийн цаг ашиглалтын коэффициентийг 85%-аар, техникийн бэлэн байдлыг 90%-аар тооцож урсгал засварыг цаг тухай бүрд хийж гүйцэтгэнэ. Үйлдвэр өдөрт 2 ээлжээр, 16 цаг ажиллана. Ээлж бүрд цэвэрлэгээ, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ. Баяжуулах үйлдвэрийн ажиллах горимын тооцооллыг дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 2. Хуурай баяжуулах хэсгийн хүчин чадал, ажиллах горим

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Дүн
1	Жилийн хуанлийн өдрийн тоо	хоног	365
2	Жилийн баяр ёслолын өдөр	хоног	4
3	Жилийн засвар үйлчилгээний хоног	хоног	31
4	Жилд ажиллах боломжит хоног	хоног	330
5	Хуурай баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	тн/цаг	950
6	Жилд ажиллах боломжит цаг	цаг	5280
7	Өдөрт ажиллах боломжит цаг	цаг	16
8	Хуурай баяжуулах үйлдвэрийн цаг ашиглалт	%	85%
9	Техникийн бэлэн байдлын коэффициент	%	90%
10	Хуурай баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	тн/хоног	15,200
	Баяжуулах нүүрсний хэмжээ	тн/жил	5,000,000
	Баяжуулсан баяжмалын хэмжээ	тн/жил	4,144,000

2.3 Үйлдвэрийн технологи

Хөшөөтийн нүүрсний уурхайн дээжид БНХАУ-ын Таншан Шенжоу компанид хийсэн хуурай аргаар баяжуулах хагас үйлдвэрлэлийн туршилтын үр дүнд үндэслэн технологийн сонголт, тооцооллыг хийсэн. Хуурай баяжуулах үйлдвэрийн хялбарчилсан технологийн схемийг зураг 3-д үзүүлээ.



Зураг 3. Хуурай баяжуулах үйлдвэрийн технологийн схем

2.4 Баяжуулалтын тоног төхөөрөмжийн ажиллах зарчим

2.4.1. ZM Хуурай баяжуулах төхөөрөмж

ZM серийн нүүрсийг ус ашиглахгүйгээр баяжуулах, өндөр үр ашигтай ангилах төхөөрөмж нь Tangshan Shenzhou Manufacturing Group компанийн олон жилийн судалгаа хөгжүүлэлт болон туршлагадаа суурилан боловсруулсан ухаалаг, хуурай аргаар боловсруулах технологийн хамгийн өндөр түвшинд хүрсэн бүтээгдэхүүн юм. Монгол улсад нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрүүдийн түгээмэл ашигладаг FGX төхөөрөмжийн дараагийн боловсронгуй хувилбар юм. ZM хуурай баяжуулах төхөөрөмжийг зураг 4-д харуулав.



Зураг 4. Нүүрс хуурай аргаар баяжуулах ZM төхөөрөмж

Технологийн давуу тал

- Ангилах нарийвчлал өндөр-бие даасан ангилах зарчмаар ажилладаг, бусад ижил төрлийн төхөөрөмжөөс ангилах нарийвчлал өндөр
- Байгаль орчинд ээлтэй-тоног төхөөрөмж нь битүү орчинд ажилладаг, галд тэсвэртэй, үндсэн хэсгүүд нь дулаан болон дуу чимээ тусгаарлах материалаар хийгдсэн, тоос барих тоног төхөөрөмж нь байгаль орчинд ээлтэй
- Ухаалаг ажиллагааны түвшин өндөр-автомат удирдлагын системтэй, ухаалаг, хүний оролцоогүй процессын явцад хяналт тавих тохиргоотой
- Модульчилсан загвар-тоног төхөөрөмж нь бүхэлдээ ган бүтэцтэй, хэрэглэгчийн

тогтоосон норм, шаардлагыг хангасан, нүүрс баяжуулах үйлдвэрт хэрэглэхэд тохиромжтой. IDS рентгенээр ялгах төхөөрөмж нь жигд тэжээх систем, туузандамжуулагч систем, рентген таних систем, дүрсээр байрлал тогтоох систем, өгөгдлийг цуглуулж боловсруулах болон үлээж гадагшлуулах систем, удирдлагын хяналтын систем зэрэг үндсэн 7 хэсгээс бүрдэхээс гадна хэмжилтийн систем, хурд хэмжих систем, тоос зайлуулах систем, цацрагийн хамгаалалтын систем, видео хяналтын систем, дохиоллын систем зэрэг 6 туслах системээс бүрдсэн.

Технологийн давуу тал

- Гараар ангилах ажлыг орлоно
- Бүхэл нүүрсийг усаар боловсруулах ажлыг орлоно
- Нүүрсний талбайн хаягдлыг ялгаж чанарыг сайжруулна
- Хаягдал дахь нүүрсний хэмжээг бууруулна
- ZM серийн боловсруулах тоног төхөөрөмжтэй хоршиж бүх төрлийн хэмжээтэй нүүрсийг ангилна, нүүрс бус түүхий эдийг ялгана.




Зураг 6. IDS рентгенээр ангилах төхөөрөмж

Технологийн давуу тал

1. Автоматаар таних, автоматаар үлээж ангилах, бүх процесст хүний оролцоо шаардагдахгүй.
2. АНУ-д үйлдвэрлэсэн хос рентген таних төхөөрөмж болон Швейцар улсад үйлдвэрлэсэн 3D камерыг ашиглан нүүрс таних өндөр нарийвчлалтай. Өгөгдлийг платформ дээр тооцоолон цэвэр нүүрс эсвэл хаягдлын байршлыг бодит цаг хугацаанд тодорхойлж, ангилдаг.
3. Үлээж ангилах нарийвчлал өндөр. Автомат үлээж ангилах механизм нь олон улсад

нэр хүндтэй импортын өндөр давтамжийн үлээх хавхлагуудыг ашигладаг бөгөөд энэ нь үр ашигтай, тогтвортой бөгөөд миллисекундээс бага хугацаанд хариу үйлдэл үзүүлэх чадвартай

4. Ангилах программаа бие даан хөгжүүлэн суралцаж, ангилах материалын өөрчлөлтийн дагуу өгөгдлийг өөрөө тохируулах боломжтой бөгөөд боловсруулалтыг хамгийн үр дүнтэй хэмжээнд хүргэх боломжтой.
5. Өндөр стандартын аюулгүй байдлын хамгаалалтын хэрэгслээр тоноглогдсон, цацрагийн үзүүлэлт нь улсын стандартаас хамаагүй бага тул аюулгүй, байгаль орчинд ээлтэй.
6. Тоног төхөөрөмжийг хэрэгцээндээ нийцүүлэн тохируулах, "нүүрсийг үлээх" эсвэл "хаягдлыг үлээх" -ийг хэрэглэгчийн хэрэгцээнд тохируулан өөрчилж, үйл ажиллагааны зардлыг үр дүнтэй бууруулж болно.



Зураг 7. IDS рентгенээр ангилах төхөөрөмжийн ялгалт хийх зарчим

2.5. Дэд бүтэц


2.5.1. Усан хангамж

Усны эх үүсвэр

Нүүрс хуурайгаар баяжуулах үйлдвэрийн унд-ахуйн усны хэрэглээг Хөшөөт голын хөндийд орших гүний 3 худгаас усны машинаар зөөвөрлөн хангана. Тус 3 худаг нь одоо ашиглагдаж байгаа ба худгуудын үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 3. Гүний худгийн үзүүлэлт

№	Худгийн нэр	Худгийн координат	Ашиглалтын ундрага, л/с	Насосны марк	Хүчин чадал, м ³ /цаг
1	Well-1	93°17'45.3" 45°50'9.04"	6.67	SEAR-NR-152-C/10	MAX 45
2	Well-2	93°17'12.6" 46°50'35.9"	9.2	SEAR-NS-95	MAX 30
3	PВ-3	93°17'10.3" 46°50'24"	6	SEAR-NS-95E/34	MAX 10



Зураг 8. Усан хангамжийн худгуудын байршил

Хөшөөт голын хөндийд байгуулсан худгууд болон булгийн усны химийн шинжилгээг лабораторид шинжилгээ хийлгүүлж бүх үзүүлэлт нь ундны усны стандартыг хангаж унд ахуйд хэрэглэхэд тохиромжтой гэж тогтоосон байна.

Өөрөөр хэлбэл “Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонат ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн бүх үзүүлэлтүүд нь ундны усны стандартын /MNS 900:2018/-н шаардлага хангаж байгаа учир хүний унданд хэрэглэхэд тохиромжтой” гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Гидрогеологи

Гидрогеологийн судалгааны ажлын хүрээнд 2007 онд Хөшөөтийн уурхайгаас 50 км радиустай талбайн хэмжээнд геофизикийн судалгаа явагдан, 5 газрын доорх устай талбайг ялган, 2015 оны байдлаар Ховд аймгийн Мөст сумын Боорчийн голын адгийн хөндий болон Хөшөөтийн голын хөндийд тус тус ашиглалтын нөөцийг батлуулсан байна. Хөшөөтийн голын хөндийд 2008, 2011 онуудад өрөмдсөн 3 цооногт шавхалт туршилтын ажлыг гүйцэтгэн газрын доорх усны нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр үнэлж 18.5 л/с буюу 1,598.4 м³/хоноогоор Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яамны (БОНХЯ)-ны Усны нөөцийн зөвлөлийн 2013.10.15 өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан. Энэ ашиглалтын нөөц нь одоогийн Хөшөөтийн уурхайн үйлдвэрлэлийн болон унд, ахуйн усны хэрэглээг бүрэн хангаж байна.

Унд ахуйн усны хэрэглээ

Ажилчдын унд ахуйн хэрэглээний усны зарцуулалтын дараах хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 4. Ажилчдын унд ахуйн хэрэглээний усны зарцуулалт

№	Ус ашиглах зориулалт	Ус ашиглах хүний тоо	Ус ашиглах стандарт (л/хүн*хон)	Унд ахуйн усны хэрэглээ		
				Өдөрт ашиглах усны хэмжээ (м ³ /хон)	Жилд ашиглах усны хэмжээ (м ³ /жил)	Төслийн нийт хугацаанд ашиглах усны хэрэглээ, м ³
1	Ажилчдын хэрэглээний ус ашиглалт	105	150	15.75	5,748.75	100,563.75

Тоос дарах усны хэрэглээ

Баяжуулах үйлдвэрийн дотор болон гадна овоолгын талбайн тоос дарах зориулалттайгаар технологийн усны хэрэглээ үүснэ. Баяжуулах үйлдвэрийн гадна байх овоолгын талбай нь нийт 10 га талбайг хамрах ба овоолго үүсгэх овоолгоос ачилт хийх явцад тоос үүсэх ба усны зарцуулалтыг бага байлгах технологийн судалгааг хийж гүйцэтгэв.

Талбайн тоос дарах технологийн судалгаа

Мананжуулагч

Мананжуулагч нь усыг маш нарийн ширхэгтэйгээр агаарт цацдаг усан буу юм. Агаарт дэгдэх тоосонцор руу цацсанаар тухайн хэсэгт үүсэх нарийн тоосыг манан хэлбэрийн усны дуслууд барьж буулгана. Мананжуулагч нь 40° хэлбэлзэлтэйгээр 100м хүртэл өндөр хүртэл манан үүсгэх давуу талтай. Мананжуулагч бууг дараах зурагт үзүүлээ.



Зураг 9. Мананжуулагч буу

Тоос дарагч шүршигч

Овоолгын талбайд овоолго үүсгэгчээс үүсэх тоосыг тоос дарах зориулалтай шүрших системийн тусламжтай багасгана. Уг шүрших систем нь салхины хурд 10м/с-ээр дээш байх үед ажилладаг. Тоос дарах шүрших системийг механик тохируулгатай тоосжилт ихээр үүсэх үед ажиллуулах боломжтой. Овоолго үүсгэгчийн шилжих цэгүүдэд усны зарцуулалт багатай шүршигч суурилуулна. Шүрших системийг зураг 10-д харуулав.



Зураг 10. Тоос дарах шүрших систем

Салхины хаалт

Бүтээгдэхүүний овоолгын талбай, гаалийн хяналтын бүс зэрэгт салхинаас үүсэх тоосыг багасгах зорилгоор салхины хаалт суурилуулдаг. Салхины хаалт нь бүс нутгийн салхины урсгал чиглэлд тохируулан байгуулна. Салхины хаалт нь бат бэх сайтай бүрээс материалаар бүрсэн ган хүрээтэй тул хуй салхинд тэсвэртэй байна. Давуу тал арчилгаа бага, усны зарцуулалт байхгүй. Сул тал анхны хөрөнгө оруулалт өндөр, байгууламж дотор үүсэх тоосыг бууруулах боломжгүй мөн гаднаас үлээх салхийг хаах ч ачилт процессын явцад үүсэх тоосыг бууруулахгүй. Төсөл хэрэгжүүлэгч “МоЭнКо” ХХК-ийн одоо ажиллаж байгаа хуурай баяжуулах үйлдвэр уг аргыг ашиглаж байна. Иймд шаардлагатай гэж үзвэл уг төсөлд дахин хэрэгжүүлэх боломжтой.



Зураг 11. Салхины наалт

Овоолгын талбайг барьцалдуулах

Эко сойл компанийн Монгол улсад нэвтрүүлж буй Дастлок Плас бүтээгдэхүүн нь байгалийн гаралтай органик нон-анионик полимер нэгдлийг овоолгын талбайг бүрснээр нягтруулах, барьцалдуулах технологи юм. Нүүрсний овоолго нь нар салхины хүчин зүйлээс хамаарч нүүрс амархан исэлдэлтэд ордог. Үүнээс хамгаалахын тулд овоолгын гадаргад цацалт хийснээр хамгаалалтын бүрхүүл үүсгэдэг. Ингэснээр овоолгын салхины алдагдалт, исэлдэлт шаталтаас бүрэн хамгаална. Уг технологийн сул тал нь хөрөнгө оруулалтын зардал өндөр, тоос дарах бодис нь ачилтын нүүрсний шинж чанарт нөлөөлж болзошгүй.

Тоос бууруулах дараах аргуудад харьцуулалт хийн төсөл захиалагчтай зөвлөлдсөний үр дүнд тоос бууруулах мананжуулагч ашиглахаар сонгов. Сонгосон тоос дарах аргын дагуу технологийн усны зарцуулалтыг тооцооллоо. Технологийн усны хэрэглээнд тоос дарах болон галын усны хэрэглээ орно. Тоос дарах усны хэрэглээг худгууд болон ил уурхайн шүүрэлтийн усаар хангана. Ил уурхайн шүүрлийн ус нь улирлын чанартай шүүрч ордог тул ашиглалтын тогтсон хэмжээг тооцох боломжгүй юм. Ил уурхайг ашиглах ТЭЗҮ-д тусгаснаар ил уурхайд 1825.25 м³/хоног ус орж ирэхээр байна. Дараах хүснэгтэд төслийн технологийн усны хэрэглээг үзүүлэв.

Хүснэгт 5. Жилд шаардагдах тенхологийн усны хэрэглээ

<u>№</u>	Ус ашиглах зориулалт	Тоос дарах талбайн хэмжээ, м ²	Ус ашиглах стандарт (L/м ² *хон)	Унд ахуйн усны хэрэглээ	
				Өдөрт ашиглах усны хэмжээ (м ³ /хон)	Жилд ашиглах усны хэмжээ (м ³ /жил)
1	Баяжуулах үйлдвэрийн тоос дарах	8,000.0	2	16	3,280
				16	3,280

ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго, зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-ний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой. Тиймээс Хөшөөтийн уурхайн бүтээн байгуулалт болон үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзээд холбогдох зардлыг төлөвлөнө. Энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

- БОМТ-г хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч дараах бодлогыг баримтална. Үүнд:
- БОМТ нь төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдсан байх;
- БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- БОМТ-г хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад тэсвэртэй болох зэрэг болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслийн хэрэгжилтийн явцад Байгаль орчинд учруулж буй гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах үндэслэл болдог. Хөшөөтийн нүүрсний ордыг ашиглах төслийн 2024 оны Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа 2012 оны 5 сард УИХ-р хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд болон БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсртуулах, хянан батлах, тайлагнах журам”-г баримталсан бөгөөд энэхүү төлөвлөгөөний гол зорилтуудыг БОУАӨЯ-р батлагдсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний үр дүндээр үндэслэн тодорхойлов.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тусгахаар хуульчлагдсаныг баримтлан боловсруулав. 2012 онд шинэчлэн баталсан хуулийн гол шаардлагуудын дагуу нэмж тодруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын гол үр дүнг тоймлон авч үзэхэд МоЭнКо ХХК-ийн Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн уурхайн нүүрсийг хуурай аргаар баяжуулах төслийн 2026

оны байгаль орчны менежментийн гол чухал зорилтууд нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах
- Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааг сайжруулах

Төлөвлөгөөний хамрах хүрээ

Бодлогын хамрах хүрээ

БОМТ нь Ховд аймгийн Дарви сумын нутагт хэрэгжих Хөшөөт ордын чулуун нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтын хүрээнд хэрэгжих бөгөөд БОННУ-ний тайлангийн 1 дүгээр бүлэгт төслийн хамрах хүрээг тодорхойлсон болно. Уг төслийн үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилт бүхий төлөвлөгөөнд БОННУ-ний тайланд тусгасан зөвлөмжүүдийн хүрээн дэх бүх асуудлыг хамрахад БОМТ нь дараах 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг менежментийн төлөвлөгөө (БОМТ),
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ).

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй биелүүлэх стандартуудыг мөрдөнө.

БОМТ-ний нийт зардал

Эдгээр гол зорилтуудыг хангах арга хэмжээнүүдийг түүний сөрөг нөлөөллийн эрчим, үр дагавраас нь хамааруулан нарийвчлан тодорхойлж байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгав. Мөнтөсөл хэрэгжих нутаг дэвсгэрт бий болох өөрчлөлт, сөрөг нөлөөллийн үр дагавар, байгальхамгаалах арга хэмжээний үр дүнг тодорхойлох, тэдгээрийг төсөл хэрэгжүүлэгч, орон нутгийнбайгууллага, иргэд сонирхогч талуудад тайлагнах хугацааг тодруулан орчны хяналтшинжилгээний хөтөлбөрийг тус тус боловсруулсан. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2025 онд нийт 86,000,000 төгрөг шаардагдах бөгөөд МоЭнКо ХХК байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан болно. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан зардал нь байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний урьдчилан тодорхойлогдох боломжтой хэсэг бөгөөд шууд гүйцэтгэлээ тодорхойлогдох, үйл ажиллагааны зардлаар хийгдэх зарим ажлуудын зардлыг энд оруулаагүй болно. МоЭнКо ХХК-ийн Хөшөөт ордын чулуун нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОУАӨЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг

батлуулан ажиллана. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт болон гүйцэтгэлийг тайлагнах ажлыг Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуй Байгаль Орчин Сургалтын (ХАБЭАБОС) албаны байгаль орчны ажилчид хариуцан ажиллах болно.

Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсвийн задаргаа

№	Хийгдэх ажлын чиглэл	Төсвийн задаргаа, төг	Ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	-	6
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19,000,000	3
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-	3
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний	2,000,000	2
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	7,000,000	4
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25,800,000	5
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28,000,000	4
8	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчидад тайлагнах төлөвлөгөө	4,200,000	3
Нийт		86,000,000	29

ДӨРӨВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян, төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Баяжуулах үйлдвэрийн гэжээлийн талбай, Технологийн зам, Гаалийн хяналтын талбайн ачиж буулгах үйл ажиллагаанаас үүсэх тоожилтын дэгдэлтийг бууруулах зорилгоор мананжуулагч машинаар усалгаа хийх, замын засвар, арчилгааг тогтмол хийлгэж хянаж байх.	Баяжуулах үйлдвэрийн зам талбайд	-	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Дулааны улиралд тогтмол хэрэгжүүлэх	Агаарын тухай хууль болон агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS 6063:2010 “агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ
2		Баяжуулах үйлдвэр болон гаалийн хяналтын талбайд үүсэх тоосжилтыг агаарт тархах тархалтыг бууруулах зорилгоор, суурин мананжуулагч буюу ус цацагч төхөөрөмжийг суурилуулж ашиглах	Баяжуулах үйлдвэрийн талбайд	Ширхэг	-	4	Үйл ажиллагааны зардлаас		
3	Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвчийн бохирдол	Төслийн үйл ажиллагааны явцад үүссэн газрын гадаргын эвдрэлд өртсөн хэсгүүдэд ажлын явцад төрх байдлын сайжруулалт хийж, ухмал нүх овоолгыг тэгшилж байх	Баяжуулах үйлдвэрийн орчимд	-	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүр	
4		Ашигласан тос маслоор газрын хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажилтнуудад сургалт зохион байгуулах	Баяжуулах үйлдвэр	-	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа	Аюултай хог хаягдлын тухай хууль
5	Төслийн үйл ажиллагаа, ус ашиглалтаас усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөлөл	Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	Усан хангамжийн эх үүсвэр, шүүрлийн ус орчмын уст цэгүүд	-	-	-	Гэрээнд заасны дагуу төлбөр төлөгдөнө	Гэрээнд заасан хугацаа бүрт	Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичгийн загварыг шинэчлэн батлах тухай (БОАЖС-ын 2018 оны 10 сарын 02-ны өдрийн А/376 дугаар тушаал)
6		Ашиглалтын гүний худаг, Түвшин буурын рашаан, Тахилтын булаг, Хөшөөт голын усны хяналт шинжилгээг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан хугацаа давтамжаар байнга хийх	Төслийн хүрээнд уст цэгүүдэд	-	-	-		Улирал бүр	
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал, мян.төг								-	

ТАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Үерийн улмаас эвдэрсэн зам талбайг засварлах / Булаг багийн Цагаан гол, Дэлгэр багийн Их сайр /	га	-	-	12,000,000	Тухай бүр	Аймгийн БОГ-с ирсэн саналын дагуу хэрэгжүүлэх
2		Сумын төв доторх замын хажуу талын болон нийтийн эзэмшлийн талбайн хонхор, гүдгэрийг тэгшилж янзлах ажилд техник хэрэгслээр дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.						
3	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний шинэ овоолгийн үржил шимийг алдагдуулахгүй хадгалалтыг уртасгахын тулд олон наст ургамлын үрээр тариалалт хийх	кг	250	30,000	7,500,000	Жил бүр	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS_5916_2008
Нийт зардал, мян.төг						19,000,000		

ЗУРГАА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймэр	Галын аюулгүй ажиллагааг чанд мөрдөн ажиллаж, гал түймэр унтраах хэрэгслэлээр бүрэн хангах, гал түймэр гарсан тохиолдолд гал түймрийг хохирол багатай унтраах арга ажиллагаанд ажиллагсдын сургаж дадлагажуулах	Төслийн хэмжээнд	-	-	-	Жилд 1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Галын аюулгүй байдлын тухай хууль
2	Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх	Ажлын байр, ажилтанд ажлын наръяд өгөх өрөө, аюултай хэсэг болон аюул, осол гарч болзошгүй газруудад анхааруулах тэмдэг, зурагт хуудас болон машин тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны заавар санамжийг ил тод харагдах газарт байрлуулах	Баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж		ХАБЭА-ын төсвөөс		Жилд 1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011
3	Тос, масло асгарах	Баяжуулах үйлдвэрийн засвар үйлчилгээний явцад гарах ашигласан тос хадгалах зөөвөрлөх сав, дэвсгэр, яаралтай цэвэрлэгээний иж бүрдэл байрлуулах.	Баяжуулах үйлдвэр генераторын хэсэг		Үйл ажиллагааны зардлаас		Тогтмол	ТЭЗҮ-ийн дагуу
Нийт зардал, мян.төг					-			

ДОЛОО. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдал ангилан ялгаж түр хадгалах торон хашаа байгуулах	Баяжуулах үйлдвэрийн талбайд	Ширхэг	1	Үйл ажиллагааны зардлаас	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль
2	Үйлдвэрийн	Сав баглаа боодол (картон, бичгийн цаас, хуванцар, металл) ангилан ялгаж пресслэх	Компанийн хэмжээнд	-	-	Тогтмол		Хог хаягдлын тухай хууль
3	Аюултай	Ухаалга баяжуулах үйлдвэрээс гарах ашигласан тосыг хуримтлуулж хадгалахад хяналт тавих, бүртгэл хөтлөх, аюултай хог хаягдлын тайлан мэдээг улирал тутам Байгаль орчны газарт хүргүүлэх	Ухаалаг баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд	-	-	Үйл ажиллагааны зардлаас		Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах журам, Хог хаягдлын тухай хууль
4		Ухаалга баяжуулах үйлдвэрээс аюултай хог хаягдалыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжээр устгуулах		жил	5,000,000	5,000,000	Жилд 1 удаа	
Нийт зардал, мян.төг						5,000,000		

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

ОХШХ нь “Хөшөөтийн уурхай” төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон түүнийг байгуулах явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорхи асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

- Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавраас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг
- Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихэсч байгааг
- Төслийн БОМТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, батлагдсан арга зүйг баримтлан стандартчилагдсан багаж, хэрэгслээр дээж, шинжилгээ хийх болон өгөгдлийг боловсруулах ажлыг МоЭнКо ХХК-ийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд удирдан явуулна. Мөн төслийн барилгын ажлыг удирдан явуулж буй компани, болон бусад гүйцэтгэгч, гэрээлэгч нар энэхүү ОХШХ-ийг үйл ажиллагаандаа баримтлах шаардлагатай.

НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Гадаргын ба газар доорхи усны хяналт шинжилгээ								
1	Усны чанарт үзүүлэх нөлөөлөл Усны орчин рН - Эрдсийн бүрэлдэхүүн - Хүнд металлын агууламж	Үйлдвэрлэлийн ойролцоох гадаргын 4 уст цэг болон гүний 3 худгаас усны дээж. Үйлдвэрийн хаягдал ус	Улирал бүр	32	125,000	4,000,000	Гадаргын усны эрдэсжилт, ЦДЧ, рН-ын агууламжыг тодорхойлуулж холбогдох стандарттай харьцуулах	MNS (ISO) 4867:1999 Усны чанар.Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Нийт						4,000,000		
Агаарын чанарын хяналт шинжилгээ								
2	Мэргэжлийн байгууллагаар баяжуулах үйлдвэрийн гадаад орчны агаарын бохирдлын судалгаа Хорт хий (CO ₂ , NO _x , SO _x) Тоос тоосонцорын судлагаа хийлгэх	Уурхай мониторингийн цэгүүд	Жилд	1-2 удаа	15,000,000	30,000,000	Агаар дахь бохирдуулагч бодисын хэмжээг тогтоож улсын стандарттай харьцуулсан тайлан гаргуулна.	MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох бодисын хэмжээг жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд)
3	Дотоод орчны эрүүл ахуйн хэмжилт (температур, харьцангуй чийглэг, шуугианы түвшин, гэрэлтүүлэг)	Үйлдвэрийн байрны дотоод 9 ажлын байранд хэмжилт хийх	Хоног	14	-	-	Хэмжилтийн мэдээг бүртгэсэн байх	MNS:6999:2023 MNS:6767:2019 MNS:6768:2019

4	Уурхай орчмын агаарын тоосонцорын /PM10/ хэмжилтийг хийлгэх	Уурхай мониторингийн цэгүүд	Хоног	14	Үйл ажиллагааны зардалаас		Хэмжилтийн мэдээг бүртгэсэн байх	MNS4585:2016 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага
Нийт					30,000,000			
Хөрсний судалгаа шинжилгээ								
5	Хөрсний мониторингийн цэгээс дээж авч хими, физик, хүнд металлын шинжилгээнд хамруулах	Ухаалга баяжуулах үйлдвэр орчмын 3 цэгээс	Улирал	12	150,000	1,800,000	Ерөнхий хими үзүүлэлт, механик бүрэлдэхүүн, хүнд металлын шинжилгээг хийлгэх	MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
Нийт							1,800,000	
ОХШХ-н нийт зардал, мян.төг							35,800,000	

ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь		Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он			
			Сар	Сар		
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба түүний биелэлтийн тайланг боловсруулах	0	0	0	Байгаль орчны орлогч менежер Б. Ганболд	Хэрэгжилт 90 %-с доошгүй байх
2	Байгаль орчны аудит хийлгэх	25,000,000	2 улиралд багтаан хийлгэх		Байгаль орчны орлогч менежер Б. Ганболд	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10-р зүйл.
3	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	1,000,000	-		2 жил тутамд 1 удаа Ховд аймгийн Онцгой байдлын газар	Галын аюулгүй байдлын тухай хууль Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам
4	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үнэлгээ хийлгэх	-	-		Жилд 1-ээс доошгүй удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 11-р сарын 10-ны өдрийн А/155 дугаар тушаал, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам
Нийт зардал, мян.төг			26,000,000			

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал мян. төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Холбогдох төрийн байгууллага	Бичгээр, цахимаар	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	11 сарын 01-нд		Хөшөөтийн уурхайн байгаль орчны баг	Аймгийн засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэгт тайлагнаж дүгнэлт гаргуулах
2	Дарви сумын ЗДТГ, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч	Бичгээр	Төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Хагас жилээр		Хөшөөтийн уурхайн байгаль орчны баг, ОНХ баг	Дарви сум

3	Байгаль орчны чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлыг олон нийтэд мэдээллэх.	Орон нутгийн сонин болон сошиал медиа	Байгаль хамгаалах чиглэлээр ажлуудыг олон нийтэд мэдээллэх хийгдсэн олон нийтэд	Тухай бүр	4,200,000	Хөшөөтийн уурхайн байгаль орчны баг, ТОНХ баг	Ховд аймаг
Нийт зардал, мян.төг		4,200,000					

ХАВСРАЛТ 1. АЖ АХУЙ НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭ

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батална.

МОНГОЛ УЛС
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2007.05.25 /Бүртгэсэн о.с, өдөр /

№ 000075706

9019023025 /Улсын бүртгэлийн дугаар /

5141583 /Фамилийн дугаар /

МОНГО

Галстур ил хөрөнгө оруулалттай хягаарлагдмал хариуцагчтай компани

/Хуулийн төлөөлдөг нэр, хяруулагчын хэлбэр /

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тушаал /шидсэрийн нэр /

A-1452 /дугаар /

2007.05.25 /о.с, өдөр /

4610 /кв /

Худгид газны зучлал /Урьдчилж эзлэх үйл ажиллагааны чиглэл /

0729 /кв /

Ашигт нөөцнийг хөгжүүлэх зориулалттай

/кв /

/Урьдчилж эзлэх үйл ажиллагааны чиглэл /

14.04.26~15.04.26 /Тэгш хэм /

1 /Төлөөлөгч /

1,170,000.00 /Ашигт нөөцний хэмжээ, манган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 4-р хороо, суун гол, Түмэнчээс 2н З рдунд, Утас: 77110567, Утас: 70110568, Факс: 77110570

/Хуулийн төлөөлдөг албан ёсын хатуу /

2020-02-27

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газар
/Бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээг зөвхөн үйлдвэрт 2014 оны 3 сар 18 өдөр

ХАВСРАЛТ 2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛБАР



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 1414А

